АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Халамжийн сангийн / улсын төсөв / 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2023/29-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2023 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Ахлах аудитор Н.Алтантуяа<br>Утас: 7033-3019<br>Цахим хаяг: Atantuyan@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.02.10 № 18

танай ____________-ны № ____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.АЗЗАЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Халамжийн сангийн /улсын төсөв/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээ нь бүрэн цахимжсан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлангийн жилд тус байгууллагын төсөв захирагч нь ХХҮЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 13-ны Б/199 дүгээр тушаалаар чөлөөлөгдөж түр орлон гүйцэтгэгч томилогдсон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн засаг даргаас 86.2 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 16,438,432.00 | - |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 16,438,432.00 | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 16,438,432.00 | - |
| 3121 | Төгрөг | 16,438,432.00 | - |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 16,438,432.00 | - |
| 33 | АВЛАГА | - | - |
| 335 | Бусад авлага | - | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | - |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 16,438,432.00 | - |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 15,952,400.00 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15,952,400.00 | - |
| 413 | Өглөг | 15,952,400.00 | - |
| 4136 | Бусад өглөг | 15,952,400.00 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 15,952,400.00 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 486,032.00 | - |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 486,032.00 | - |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 486,032.00 | - |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,117,125.63 | 486,032.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (6,631,093.63) | (486,032.00) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 16,438,432.00 | - |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 6,000,389,307.14 | 95,160,500.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,842,307.14 | 144,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,842,307.14 | 144,500.00 |
| 120002 | Хүүгийн орлого | 19,633.74 | - |
| 120009 | Бусад орлого | 8,822,673.40 | 144,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,991,547,000.00 | 95,016,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 5,991,547,000.00 | 95,016,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 6,007,020,400.77 | 95,646,532.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,007,020,400.77 | 95,646,532.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 29,819,300.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 29,819,300.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,168,000.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,651,300.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,977,201,100.77 | 95,646,532.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,933,197,021.39 | 79,747,310.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 5,933,197,021.39 | 79,747,310.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 44,004,079.38 | 15,899,222.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 44,004,079.38 | 15,899,222.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (6,631,093.63) | (486,032.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (6,631,093.63) | (486,032.00) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 15,345,433,531.23 | 102,271,890.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 35,538,941.23 | 7,255,890.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 35,538,941.23 | |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 19,634.74 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,634.74 | - |
| 120009 | Бусад орлого | 35,519,306.49 | 7,255,890.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 15,309,894,590.00 | 95,016,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 15,309,894,590.00 | |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 15,309,894,590.00 | 95,016,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 6,039,198,168.38 | 118,710,322.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,039,198,168.38 | - |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 29,192,900.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 29,192,900.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 27,541,600.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,651,300.00 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,966,001,188.00 | 102,811,100.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 5,966,001,188.00 | 102,811,100.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 44,004,080.38 | 15,899,222.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 44,004,080.38 | 15,899,222.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 9,306,235,362.85 | (16,438,432.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 9,306,235,362.85 | (16,438,432.00) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 60,635,190.24 | 16,438,432.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 28,550,659.15 | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| № | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | | 7,117,125.63 | 7,117,125.63 |
| 2 | Тайлант үеийн үр дүн | | -6,631,093.63 | -6,631,093.63 |
| 3 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 486,032.00 | 486,032.00 |
| 4 | 2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 0.00 | 486,032.00 | 486,032.00 |
| 5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | 0.00 | 0.00 |
| 6 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 486,032.00 | 486,032.00 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | -486,032.00 | -486,032.00 |
| 8 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 179,700,000.00 | 95,555,210.00 | 84,144,790.00 | 53.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 179,700,000.00 | 95,555,210.00 | 84,144,790.00 | 53.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 179,700,000.00 | 95,555,210.00 | 84,144,790.00 | 53.2 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 179,700,000.00 | 95,555,210.00 | 84,144,790.00 | 53.2 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 179,700,000.00 | 95,555,210.00 | 84,144,790.00 | 53.2 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 179,700,000.00 | 95,555,210.00 | 84,144,790.00 | 53.2 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 179,700,000.00 | 95,555,210.00 | 84,144,790.00 | 53.2 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 179,700,000.00 | 95,555,210.00 | 84,144,790.00 | 53.2 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 16,438,432.00 | (16,438,432.00) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - | | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно. Иймд Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Халамжийн сан | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |